



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 06 сарын 03 өдөр

Дугаар 9/107

Ховд

Г
Ес зүйн зөвлөлийн ажиллах журмыг
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолын хавсралтын 6.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Ес зүйн зөвлөлийн ажиллах журмыг хавсралтаар баталсугай.
2. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагч нарт хууль тогтоомж, үйл ажиллагаагаа сурталчилан ажиллахыг Ес зүйн зөвлөлд үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ЭНХБОЛД



03.06.19
D/Tush-A/107-Da



Аймгийн Засаг даргын Тамгын газрын
даргын 2019 оны 06 дугаар сарын 14-ний
өдрийн А/107 дугаар тушаалын хавсралт

ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Ёс зүйн зөвлөл нь /цаашид “Зөвлөл” гэх/ “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн хэрэгжилтэд хяналт тавих, ёс зүйн зөрчил гаргасан талаарх асуудлыг шалгаж, хариуцлага хүлээлгэх үндэстэй эсэх талаар дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус байгууллага мөн.

1.2. Зөвлөл нь “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, холбогдох хууль тогтоомж болон энэхүү журмын хүрээнд үйл ажиллагаа явуулна.

1.3. Зөвлөл нь үйл ажиллагаанд тэгш хандах, шударга ёсыг баримтлах, нууцыг хадгалах, хараат бус байх зарчмыг баримтална.

Хоёр. Ёс зүйн зөрчлийн тухай мэдээллийг хүлээж авах,
шалгаж шийдвэрлэх

3.1. Зөрчлийн тухай мэдээллийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэс хүлээн авч хяналт шалгалт явуулан дүнг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргад танилцуулж, ёс зүйн зөвлөлд хүргүүлнэ.

Гурав. Ёс зүйн зөвлөл

2.1. Зөвлөл нь аймаг Засаг даргын Тамгын газрын даргын дэргэд нийт ажилтнуудын хурлаас санал авч сонгогдсон төлөөлөл бүхий 5 хүний бүрэлдэхүүнтэй байна.

2.2. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг 3 жил тутам шинэчилнэ.

2.3. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга батална.

2.4. Зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга болон гишүүдийн бүрэлдэхүүнтэй байна.

2.5. Зөвлөлийн гишүүн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гишүүнээс чөлөөлж, нөхөн сонгоно.

2.6. Зөвлөл нь дараах чиг үүрэгтэй. Үүнд:

2.6.1. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сурталчлан таниулах, санал, зөвлөмж өгөх;

2.6.2. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн мэргэжлийн болон хувь хүний ур чадвар, хандлагад эерэг нөлөө үзүүлэх сургалт тогтмол зохион байгуулах;

2.6.3. Ёс зүйн зөрчил болон ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд дүн шинжилгээ хийж, учир шалтгааныг магадлан тогтоож шийдэх арга замыг тодорхойлох;

2.6.4. Хууль бус ямар нэгэн үйлдлээс урьдчилан сэргийлэх, сөрөг үр дагавар үүссэн нөхцөл байдлыг арилгах, зөрчил дахин давтагдахгүй байхад чиглэсэн урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа хэрэгжүүлэх;

2.6.5. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ажилтны ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, дүгнэлтийг хүлээн авах;

2.6.6. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэх асуудлаар шалгалт явуулж, дүгнэлт гаргах, хариу өгөх;

2.6.7. “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг хэрэгжүүлэх талаар төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийн талаар олон нийтэд болон Төрийн албаны төв байгууллагад тайлагнах;

2.6.8. Ёс зүйн зөрчил, хариуцлагын талаар мэдээллийн сан бүрдүүлнэ.

2.7. Зөвлөлийн гишүүн нь ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэх асуудлыг шалгах, нууцыг чанд хадгалах, хуралд оролцож санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хурлаас гарах шийдвэрт хариуцлагатай оролцох, ёс зүйн зөрчил гарсан эсэхэд саналаа хэлэх, зөвлөлийн даргын томилсноор зөвлөлийн хурлыг даргалах бүрэн эрхтэй.

2.8. Зөвлөлийн дарга нь зөвлөлийн гишүүний бүрэн эрхээс гадна зөвлөлийн хурлыг товлон зарлах, бэлтгэлийг хангуулах, хурлыг удирдах, гомдол, хүсэлтийг хүлээн авах, өөрийн эзгүйд зөвлөлийн хурлыг удирдах гишүүнийг томилох бүрэн эрхтэй.

2.9. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь зөвлөлийн гишүүний бүрэн эрхээс гадна зөвлөлийн хурлын бэлтгэл ажлыг хангах, хурлын тэмдэглэл хөтлөх, хурлаас гарсан шийдвэрт бүх гишүүдээр гарын үсэг зуруулж, баталгаажуулах, баримт бичгийг эмхэлж архивын нэгж болгох, зохих байгууллага, хувь хүнд ёс зүйн зөвлөлийн дүгнэлтийг хүргүүлэх зэрэг ажлыг гүйцэтгэнэ.

2.10. Ёс зүйн зөвлөлийн гишүүн дараах тохиолдолд гомдол, хүсэлтийг хянан шалгах ажиллагааг явуулж болохгүй.

2.10.1. Гомдол, хүсэлтийг өөрөө гаргасан бол;

2.10.2. Өөрөө шууд буюу шууд бусаар уг асуудалд хувийн сонирхолтой гэж үзэх үндэслэл байгаа бол;

2.11. Зөвлөлийн гишүүдийн ердийн ирцтэй хурлын шийдвэрийг хүчинтэйд тооцно.

2.12. Хурлын шийдвэр гишүүдийн олонхийн саналаар хүчин төгөлдөр болно.